

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2023 оны 11 дүгээр сард хийсэн ажлын товч мэдээ

2023 оны 11 дүгээр сарын 22

Дархан-Уул аймаг

Аймгийн Засаг даргын баталсан “Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2023 онд хийх хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Тулга сувилал ОНӨААТҮГазар, Хонгор сумын Соёлын төвийн 2021-2022 оны үйл ажиллагаанд дотоод аудит хийж дуусган дотоод аудитын ажлын тайланг хүргүүллээ. Илэрсэн зөрчилд Тулга сувилал ОНӨААТҮГазарт 3 акт, 1 албан шаардлага, 4 зөвлөмж, Хонгор сумын Соёлын төвд 3 акт, 11 зөвлөмж тус тус өглөө. Ажлын тайлангийн товч танилцуулгыг байгууллагын цахим сайт <https://sankhuu.audit.da.gov.mn/-ээп> мэдээлж байна.

Мөн төлөвлөгөөний дагуу Замын сан, Эрүүл мэндийн газрын 2021,2022 оны үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалтыг хийж, холбогдох ажилтануудтай сонсох ажиллагааг явуулж байна.

Боловсрол, шинжлэх ухааны газарт санхүүгийн хяналт шалгалт, Залуучууд театр, Дархан-Уул аймаг дахь шүүх шинжилгээний бүсийн төвд дотоод аудит хийхээр удирдамжийг аймгийн Засаг даргаар батлуулан холбогдох байгууллагуудад хүргүүлж баримтыг хүлээн авч байна.

Төрийн байгууллага, албан хаагчдад харилцааны соёл, үйл ажиллагаандаа баримтлах дэг, жаягийг нийтлэг байдлаар танилцуулах, анхаарал хандуулах зарим асуудлаар танин мэдэхүйн болон практик мэдээлэл зөвлөмж өгөх зорилгоор ТАЗ-өөс зохион байгуулж буй 7:4:10 “Аз жаргалтай ажлын байр-Стресс менежмент”, “Амжилтад хүрэх хүсэл”, “Шинэ зууны манлайллын хэв маягууд”, “Монгол улсын тусгаар тогтнол ба Богд хаан” сэдэвт цахим сургалтад 9 албан хаагч хамрагдлаа.

"Бүх нийтийн сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих төсөл" -ийн "Сэтгэл зүйн нөөцөө хэрхэн үр дүнтэй удирдах вэ?" сургалтад тус алба болон Дархан сумын ЗДТГ, Статистикийн хэлтэсийн албан хаагчид хамрагдлаа



Тус албаны 3 албан хаагч ОРОН НУТГИЙН ТӨСӨВ БА ИРГЭДИЙН ОРОЛЦОО" хэлэлцүүлэгт оролцлоо.



Удирдлагын академиас улсын төсвийн санхүүжилтээр төрийн байгууллагын шийдвэр хууль зүйн үндэслэл, хууль хэрэгжүүлэх онол, арга зүйн талаар цэгцтэй мэдлэг чадвартай болох зорилгоор “Төрийн байгууллагын шийдвэр; Хууль хэрэглээ” сэдэвт богино хугацааны ажлын байран дахь сургалтыг 11 дүгээр сарын 15,16-ны өдөр зохион байгуулахад тус албаны 2 албан хаагчид хамрагдлаа.



Сангийн яам Төсвийн тухай хуульд заасан чиг үүргийнхээ хүрээнд төрийн байгууллагуудын дотоод аудитор, санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчдад зориулсан сургалтыг 2023 оны 11 дүгээр сарын 16, 17 -ны өдөр зохион байгуулахад тус албаны албан хаагчид хамрагдлаа.



САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА